



**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 21 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 199

Даланзадгад сум

**Журам шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2. "ж", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Ойн салбарын зөвлөгөөний хэлэлцүүлгээс гарсан саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. "Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлд урамшуулал олгох журмыг нэгдүгээр, мод тарьж ургуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлд урамшуулал олгох гэрээний маягыг хоёрдугаар, иргэдийн өргөдөл, хүсэлтийн маягыг гуравдугаар, урамшууллын гэрээгээр тарьсан модыг хүлээж авсан актны загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Өмнөх журмаар гэрээ байгуулсан этгээдтэй гэрээг шинэчлэн байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Х.Отгонмөнх)-д, урамшуулалд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга (Р.Сэддорж)-д даалгасугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан мод тарьж ургуулах хөдөлгөөн өрнүүлэх, мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллахыг орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад уриалсугай.

4. Энэхүү журмыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт мөрдөж эхлэх бөгөөд уг тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 51 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА




Б.БАДРАА

461200225



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 199 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

**МОД ТАРЬЖ УРГУУЛСАН ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГА,  
НӨХӨРЛӨЛД УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**



**Нэг. Ерөнхий зүйл**

Энэхүү журмын зорилго нь говийн бүсийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, элсний нүүлтийг багасгах зорилгоор мод тарьсан, ногоон зурвас, төгөл, баянбүрд байгуулсан иргэн, аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөлийн үйл ажиллагааг орон нутгаас дэмжин мөнгөн хэлбэрээр урамшуулахад оршино.

Иргэн 9 -өөс дээш, аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөл 90 -ээс дээш зөвхөн 2-3 настай суулгацыг технологийн дагуу тарьсан нөхцөлд энэхүү урамшуулалд хамрагдах нөхцөл бүрдэнэ. Хоёр настай суулгац тарьсан эхний жилийг 1 настай мод гэж тооцно.

Өмнө нь мөрдөж байсан журам нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 51 дүгээр дүгээр тогтоолоор батлагдсан бөгөөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэн, тарьц, суулгацын үнэ өссөн, мод тарьдаг иргэдийн санал зэргээр урамшууллын мөнгөн дүнг нэмэх шаардлага гарсан тул урамшууллын журмыг шинэчлэн боловсруулав.

Журмыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхлэх бөгөөд өмнөх журамд хамрагдаж гэрээ байгуулсан этгээдтэй гэрээг шинэчлэн байгуулах.

**Хоёр. Оролцогчдын хүсэлтийг хүлээн авч бүртгэх**

2.1. Мод тарьж урамшууллын журманд хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл өргөдөл хүсэлтээ тухайн жилийн 5 дугаар сарын 20-нд багтаан сумын салбар комисст батлагдсан маягтын дагуу бичгээр гаргана.

2.2. Иргэний өргөдөл буюу аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлийн хүсэлтэд ойжуулах, ойн зурвас байгуулах, мод тарих талбайн байрлал хэмжээ, байршлын тойм зураг, хийж гүйцэтгэх ажлын дэлгэрэнгүй танилцуулга, тооцоо судалгааг хавсаргасан байна. Мөн ойжуулалт хийх иргэн, аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөлийн ойжуулах талбай нь өөрийн эзэмшил, өмчлөлд байх бөгөөд талбайн хамгаалалт, услалтын асуудлыг бүрэн шийдсэн байна. Хугацаа хоцорсон тохиолдолд өргөдлийг хүлээн авахгүй.

2.3. Аймгийн Засаг даргын захирамжаар гэрээнд оролцогчдын ургасан модыг тоолох, хяналт хийх, хүлээн авч акт үйлдэх, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий тусгай комиссыг томилон ажиллуулна. Энэхүү комисс нь мэргэжлийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хөндлөнгийн аудитаас бүрдсэн байх бөгөөд байнгын ажиллагаатай байх тул албан тушаалаар томилно. Сумдын Засаг даргын захирамжаар сумдад энэхүү комиссын салбар комисс байгуулагдах ба аймгийн комисс түүнийг удирдлагаар хангаж ажиллана.



2.4.Энэ журмын 2.3-т заасны дагуу томилогдсон комисс нь дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

2.4.1. Энэ журмын 2.1-д заасны дагуу ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч тухайн оны 05 дугаар сарын 25-ны дотор аймгийн комиссын хурлаар өргөдөл, хүсэлтийг нэг бүрчлэн авч хэлэлцээд 3.1-т заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг хянаж, гэрээ байгуулах болон материалыг буцаах эсэх талаар шийдвэр гаргана.

2.4.2. Энэ журмын 2.4.1-д заасны дагуу буцаахаар шийдвэрлэсэн өргөдөл, хүсэлтийг албан тоотой эзэнд нь хүргүүлэх ба уг тоотод урамшууллын журмын дагуу гэрээ байгуулахаас татгалзах болсон үндэслэлийг заавал дурдсан байна.

2.5. Журмын 2.4.1-г үндэслэн 3.1 дэх шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа этгээдтэй Байгаль орчин аялал жуулчлалын газар батлагдсан гэрээний маягтаар гэрээ байгуулна. Гэрээг 3 хувь үйлдэж, гэрээ байгуулагч 2 тал, сумын салбар комисс тус бүр нэг хувь хадгална.

2.6. Гэрээ байгуулахдаа тарих модны нэр төрөл, мод хоорондын зай, эгнээ хоорондын зайг нарийн тусгаж өгсөн байна. Модны урамшуулал олгохдоо дараах жишгийг баримтална.

#### Тарих модны төрөл хоорондын зай /м/

№	Тарьж ургуулах мод	Төрөл	Эгнээ хоорондын зай	Мод хоорондын зай
1	Мод, мод хэлбэрийн	Хайлаас, улиас, тоорой, жигд, чацаргана, Алим, Чавга, Агч, Бургас, Сухай, Бүйлс, Шар хуайс	2.0 метрээс дээш	1.0 метрээс дээш
2	Бут, сөөг	Харгана, тошлой, голт бор, үхрийн нүд, заг,	1.5 метрээс дээш	

#### Гурав. Урамшууллын гэрээнд хамрагдах үндсэн шаардлага болон хориглох заалт

3.1.Оролцогч нь дор дурдсан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

3.1.1 Ойжуулалт хийх талбай нь өөрийн эзэмшил, өмчлөлд байх бөгөөд талбайнхаа хамгаалалт, усалгаа, арчилгааг бүрэн хариуцсан байх

3.1.2 Төв суурингийн нийтийн эзэмшлийн талбайд, бэлчээр, булаг шандны эхийн ундаргыг сайжруулах зорилгоор, тариалангийн талбайг хамгаалах зориулалтаар мод тарьж, ойн зурвас баян бүрд, төгөл байгуулах

3.1.3 Гэрээнд заасан нөхцөл стандартын дагуу мод тарьж ургуулсан иргэн аж ахуй нэгж, нөхөрлөлд урамшуулал олгох ба гэрээг зөрчсөн тохиолдолд гэрээг цуцална.

3.1.4. Иргэн 9- өөс дээш, аж ахуй нэгж байгууллага 90-ээс дээш мод тарих



3.2. Дор дурдсан тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг энэхүү урамшууллын гэрээнд хамруулахыг хориглоно.

3.2.1 Мод үржүүлэг, тарьц суулгац бойжуулах зорилгоор мод тарих

3.2.2 Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн хүрээнд ойжуулалт хийх, ойн зурвас байгуулах

3.2.3. Уул уурхай болон байгаль орчинд шууд сөрөг нөлөө үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэгчид нөхөн сэргээлтийн зориулалтаар, байгууллага, аж ахуйн нэгж нь “Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ”- ний дагуу байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мод тарих

3.2.4. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллагаас мод тарилттай холбоотой санхүүжилт авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тарьсан модыг хамруулах

3.2.5 Байгууллагын гаднах орчныг тохижуулах зорилгоор мод тарих

3.2.6 Өмнө нь тарьсан модоо урамшууллын гэрээнд хамруулах

### **Дөрөв. Гүйцэтгэлийг хүлээн авах зохион байгуулалт, урамшуулал олгох**

4.1. Журмыг хэрэгжилтийг аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар хариуцан зохион байгуулж ажиллах бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газар удирдлагаар хангаж ажиллана.

4.2. Сумын салбар комисс мод тарьж гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагын модонд явцын хяналтыг 07 дугаар сард хийж модны ургалтын байдалд дүгнэлт хийнэ.

4.3. Гэрээ байгуулж мод тарьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын модыг энэ журмын 2.3-т заасан аймгийн комисс болон сумын салбар комисс тухайн жилийн 10 дугаар сарын 15-ны дотор нэг, хоёр, гурав дахь жилдээ ургаж байгаа мод нэг бүрийг тоолж, журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу акт үйлдэн, гэрэл зургийг нь авч баримтжуулна.

4.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, мод тариагүй этгээдийн гэрээг үл маргах журмаар цуцална.

4.5. Аймгийн комисс урамшууллын гэрээний үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй тайлан, тухайн жилийн ойжуулалтын ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан тооллогын дүнг нэгтгэн, хөрөнгийн тооцоог гаргаж 11 дүгээр сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулна.

4.6. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар тооллогын тайлан, нэгтгэсэн дүнг хэлэлцүүлж 12 дугаар сарын 10-ны дотор модны урамшууллыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн дансанд шилжүүлж, урамшуулал олгосон жагсаалтыг Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.

4.7. Энэ журмын 4.3-д заасны дагуу батлагдсан акт нь тарьсан модонд урамшуулал олгох эцсийн дүн болно.



4.8. Энэ журмын 4.3-д заасан тооллогоор үйлдсэн акт, тухайн хөрөнгийн эх үүсвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга “Урамшуулал олгох тухай” шийдвэр гаргах ба урамшууллыг оролцогчийн тарьж ургуулсан мод нэг бүрт дор дурдсан үзүүлэлтийг харгалзан тооцож бодно.

Тарьсан модны насны ангилал	Урамшуулал /төгрөгөөр/
1 настай / 2-3 настай суулгацыг тарьсан эхний жил/	3000
2 настай	4500
3 настай	6000

4.9. Урамшууллыг олгохдоо 1 настай модонд урамшууллын 60%, 2 настай модонд урамшууллын 80%, 3 настай модонд урамшууллыг 100% бодож 3 дахь жилд 1, 2 настай модны урамшууллын үлдэгдэл болох 40, 20 хувийг нэмж олгоно.

Жишээлбэл: 10 мод тариад 3 жилийн хугацаанд 135000 төгрөгийн мөнгөн урамшуулал авна.

Стандартын шаардлага хангасан суулгац	Урамшууллын нас	Урамшуулал /төгрөгөөр/	Модны тоо: Жишээ авч үзвэл	Нийт олгох мөнгөний хэмжээ /төг/	60% / Мод тарьсан эхний жил/ -р тооцон олгоно /төг/	80 % /Мод тарьсан 2 дахь жил/- р тооцон олгоно /төг/	100%+ 40% + 20 % /Мод тарьсан 3 дахь жил/ нийт олгох төгрөг
2 - 3 нас	1 нас	3000	10	30000	18000	-	-
3 - 4 нас	2 нас	4500	10	45000	-	36000	-
4 - 5 нас	3 нас	6000	10	60000	-	-	60000+12000 /эхний жил/+ 9000 /2 дахь жилийн үлдэгдэл/ = 81000 төгрөг
<b>3 жилийн хугацаанд авах мөнгөн дүн /135,000₮/</b>					18000	36000	81000

#### Тав. Санхүүгийн эх үүсвэр

5.1. Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгж байгууллага нөхөрлөлийн урамшууллыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлэх бөгөөд дээрх хөрөнгийг Байгаль хамгаалах санд төвлөрүүлнэ. Үүнд:

- Улсын төсөв
- Орон нутгийн төсөв



- Аж ахуй нэгж байгууллагын хандив тусламж
- Мод тариагүй иргэн аж ахуй нэгжийн нөхөн төлбөр
- Бусад

### **Зургаа. Бусад**

Гүйцэтгэгч нь урамшуулал авсан модны 50 хувиас илүүг хамгаалж, арчлаагүй үхүүлсэн, мал амьтанд идүүлсэн тохиолдолд урамшууллын журмаас хасна. Үрэгдүүсэн модны тоогоор нөхөн тарилт хийх албан шаардлага тавина.

Энэхүү журмын 2.1-д заасан өргөдөл хүсэлтийн маягт, 2.5-т заасан гэрээний маягт, 4.3-д заасан мод хүлээн авах актын загвар зэргийг журмын хавсралтаар батална.

### **Долоо. Нэмэлт болзол**

Дараах тусгай болзлыг хангасан иргэн, аж ахуй нэгж, нөхөрлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар шагнаж урамшуулна.

7.1. Байгаль орчинд ээлтэй шинэ техник технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулна.

7.2. Говийн нөхцөлд тохирсон мод, сөөг, сөөгөнцөр, бутлаг ургамлыг хамгийн их /10000-аас дээш/ тарьж хамгаалсан иргэн, аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөлийг шалгаруулж урамшуулна.

7.3. Нэг шалгаруулсан иргэн, байгууллага, аж ахуй нэгжийг 3 жилд дахин шалгаруулахгүй бөгөөд жил болгон дээрх болзлуудыг шалгаруулж модны урамшуулалтай хамт урамшуулал олгоно.

--oOo--



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 199 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

Батлав.  
Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал  
салбар комиссын  
жуулчлалын газрын дарга / /

Батлав.  
..... сумын  
дарга / /

**МОД ТАРЬЖ УРГУУЛСАН ИРГЭН АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГАД  
УРАМШУУЛАЛ ОЛГОХ ГЭРЭЭ**

20\_ оны\_\_ сарын\_\_ өдөр

Даланзадгад

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 20..... оны ..... дугаар тогтоолоор батлагдсан “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын 2.5 дахь заалтыг үндэслэн захиалагчийг төлөөлж Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн нөөц, хамгаалал, ойжуулалт хариуцсан мэргэжилтэн .....овогтой....., гүйцэтгэгчийг төлөөлж ..... овогтой ..... нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний салшгүй хэсэг нь “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллага, нөхөрлөлд урамшуулал олгох журам”-ын 2.2 дах заалтад заасан баримт бичиг байна.

**Хоёр. Гэрээний нөхцөл**

2.1. Мод тарьж урамшуулалд хамрагдах ..... овогтой ..... -ийн тарьж ургуулсан мод нэг бүрт Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 20..... оны ..... сарын .....-ны өдрийн ..... дугаар тогтоолоор батлагдсан “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын 4.8 дах заалтыг үндэслэн дор дурдсан үзүүлэлтээр урамшуулал бодно. Үүнд:

Тарьсан модны насны ангилал	Урамшуулал /төгрөгөөр/
1 настай	3000
2 настай	4500
3 настай	6000

2.2. Урамшууллын гэрээнд хамрагдаж тарьсан модыг томилогдсон ажлын хэсэг намрын тооллогоор тоолж урамшуулал олгох бөгөөд олгохдоо 1 настай модонд урамшууллын 60%, 2 настай модонд урамшууллын 80%, 3 настай модонд урамшуулалыг 100% бодож 3 дахь жилд 1, 2 настай модны урамшууллын үлдэгдэл болох 60 хувийг нэмж урамшууллыг олгоно.



2.3. Урамшууллыг гүйцэтгэгчийн дансанд буюу бэлнээр олгоно.

### Гурав. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг

3.1. “Газрын тухай” хууль, “Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулийн дагуу өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа .....сумын ..... нэртэй газар .....га талбайд ..... ш модыг доорх стандартын дагуу тарьж ургуулна.

#### Тарих модны төрөл хоорондын зай /м/

№	Тарьж ургуулах мод	Төрөл	Эгнээ хоорондын зай	Мод хоорондын зай
1	Мод, мод хэлбэрийн	Хайлаас, улиас, Тоорой, Жигд, чацаргана, Алим, Чавга, Долоогоно, Монос, Агч, Бургас, Сухай, Бүйлс, Шар хуайс, Шилмүүст төрлийн мод	2.0 метрээс дээш	1.0 метрээс дээш
2	Бут, сөөг	Харгана, тошлой, голт бор, үхрийн нүд, заг,	1.5 метрээс дээш	

3.2. Суулгасан тарьц суулгацаа технологийн дагуу усалж арчлан ургуулах, талбайгаа хашиж хамгаалах асуудлыг бүрэн хариуцна.

3.3. Тухайн жилийн 9-11 сард багтаан энэ журмын 2.3-т заасан комисст тарьж ургуулсан модоо нэг бүрчлэн тоолуулж, акт үйлдүүлж нэг хувийг авсан байна.

3.4. Мод тарьсан газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад шилжүүлсэн бол захиалагчид заавал мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй.

### Дөрөв. Захиалагчийн хүлээх эрх, үүрэг

4.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу мод тарьж ургуулж байгаа эсэхийг хянах

4.2. Энэхүү гэрээг тухайн жилийн 05 дугаар сард багтаан байгуулах ба гэрээ байгуулсан 2 тал тус бүр 1 хувь, үлдсэн 1 хувийг сумын салбар комисст хүргүүлнэ.

4.3. Энэхүү гэрээг жил бүр дүгнэж, энэ гэрээний 4.3-т заасан комиссийн дүгнэлтийг үндэслэн 4.6-д заасан үндэслэлээр бодож 4.7-д заасан үнэлгээгээр урамшууллыг олгоно.

### Тав. Бусад

5.1. Энэхүү гэрээг 3% үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаатай байгуулав.

5.2. Хоёр тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцална.

5.3. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.



**Зургаа. Талуудын хаяг:**

Захиалагч:  
Аймгийн Байгаль орчин, аялал  
жуулчлалын газрын мэргэжилтэн

Гүйцэтгэгч:  
..... сумын иргэн  
..... овогтой

.....  
*/гарын үсэг /*  
Хаяг: Нутгийн удирдлагын ордон

*/гарын үсэг/*  
Хаяг:

.....  
101 тоот  
Утас: 7053-2148

Утас: .....

--oOo--



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 199 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



\_\_\_\_\_ сумын Засаг даргын  
Тамгын газарт өргөдөл гаргах нь:

Урамшууллын гэрээнд  
хамрагдах хүсэлт гаргах тухай

20... оны ..... –р сарын .....-ны өдөр  
..... сум

..... сумын.....дугаар/дүгээр багийн .....  
газарт/тоотод оршин суудаг ..... овогтой ..... миний бие "Газрын  
тухай", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулиудын дагуу .....  
/эзэмшил, өмчлөл/-д байгаа ..... сумын ..... нэртэй,  
..... га хэмжээтэй газарт дор дурдсан төрлийн нийт ..... ширхэг модыг тарьж ургуулахаар  
төлөвлөж байгаа тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны ..... дугаар тогтоолоор  
батлагдсан "Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлд урамшуулал  
олгох журам"-ын дагуу урамшууллын гэрээнд хамруулж өгөхийг хүсье. Тарих модыг төрлөөр  
нь авч үзвэл:

Тарьж ургуулах модны төрөл	Тарих тоо
1/	
2/	
3/	
Дүн	

Өргөдөл гаргагч ..... миний бие тус сумын  
..... газарт ..... ажилтай бөгөөд  
энэхүү гэрээнд хамрагдсанаар манай ам бүлийн ..... /энэ тоог заавал бичих/  
гишүүний амьжиргааны төвшин дээшилж, байгаль орчныг нөхөн сэргээхэд үнэтэй хувь  
нэмрээ оруулах болно.

Ойжуулалт хийх талбайн байршлыг харуулсан тойм зураг, хийж гүйцэтгэх  
ажлын дэлгэрэнгүй танилцуулга /усалгааны шийдэл, тарьц суулгацын төрөл, нөөц гэх  
мэт/ шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцоо зэргийг хавсаргав.

Өргөдөл гаргасан: ..... сумын  
..-р багийн иргэн .....

Хаяг.....

Утас: .....



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны  
өдрийн 199 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт

УРАМШУУЛЛЫН ГЭРЭЭГЭЭР ТАРЬСАН  
МОДЫГ ХҮЛЭЭЖ АВСАН АКТ



.....оны..... -р сарын .....-ны өдөр дугаар.....

Өмнөговь аймгийн Засаг даргын/сумын Засаг даргын ..... оны ..... тоот захирамжаар томилогдсон ойжуулалтын ажлыг хүлээн авах комисс ..... сумын Засаг даргын Тамгын газартай ..... онд байгуулсан “Мод тарьж ургуулсан хуулийн этгээдэд урамшуулал олгох гэрээ”-ний дагуу ..... овогтой.....-ны гүйцэтгэсэн ойжуулалтын ажлын хэмжээ, чанар, үр дүнг газар дээр нь шалгаж үзэхэд:

..... сумын ..... нэртэй газар ..... модыг 20..... оны..... дугаар сарын .... –нээс тарьж ургуулсныг /эхний жилийн, хоёр дахь жилийн, гурав дахь жилийн/ намрын тооллогоор мод нэг бүрийг тоолж үзэхэд:...../ ...../ ширхэг таримал мод ургасан байв. Таримлын жилийн өсөлт нь ..... см, ерөнхий байдал нь ..... байв. Таримал модыг төрлөөр нь авч үзвэл:

№	Тарьсан модны төрөл	Анх тарьсан тоо	Тооллогоор ургасан модны тоо

Ойжуулалтын ажлын гүйцэтгэл, газар дээр нь явуулсан тооллого, судалгаанаас үндэслэн комиссоос ТОГТООХ нь:

1. “Мод тарьж ургуулсан хуулийн этгээдэд урамшуулал олгох гэрээ”-ний дагуу ..... овогтой .....-ны ..... сумын ..... нэртэй газарт нийт ..... ширхэг мод тарьж ургуулсныг намрын тооллогоор /эхний жилийн, хоёр дахь жилийн, гурав дахь жилийн/ таримал мод нэг бүрийг тоолж үзэхэд: ...../ ...../ ширхэг таримал мод ургасан болохыг тогтоов.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын газартай ..... онд байгуулсан гэрээний дагуу тарьсан модноос ургаагүй ..... ширхэг модыг ..... оны ..... -р сард нөхөн тарилт хийснээс:...../...../ ширхэг нь ургасан болохыг тогтоов.

3. Гүйцэтгэлийн хэмжээ, чанар үр дүнгийн байдал, “Мод тарьж ургуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагад урамшуулал олгох журам”-ын 4.9 дэх заалтыг үндэслэн /эхний жилийн, хоёр дахь жилийн, гурав дахь жилийн/ урамшуулал болох: ...../ ...../ төгрөгийг гүйцэтгэгчид олгох нь зүйтэй гэж үзэв.

4. Комиссоос өгөх зөвлөмж:

.....



.....  
.....  
.....

АКТ ТОГТООСОН:

КОМИССЫН ДАРГА: .....

ГИШҮҮД: .....

.....  
.....  
.....

ЗӨВШӨӨРСӨН: .....овогтой .....

/Гүйцэтгэгч/

Регистрийн дугаар:..... Утас: .....

Дансны дугаар: ..... банкны ..... тоот

--oOo--